



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/790

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, “Үйлдвэрлэгч Ховд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Үйлдвэрлэгч-Ховд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Хан Алтайн инээмсэглэл” бүрэн бус нөхөрлөлийн “Амин хүнс” сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах цехийн үйл ажиллагааг өргөтгөх төслийг дэмжин байгуулсан гэрээ, санхүүжилтийн эрхийг үндэслэн зээл олгосугай.

2. Зээл олгох аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

3. Дээрхи арга хэмжээнд зарцуулах 5 573 618 төгрөг /таван сая таван зуун далан гурван мянга зургаан зуун арван найман мянга/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт орон нутгийн хөгжлийн сангийн 5.31-д заасан “Үйлдвэрлэгч Ховд” өрхийн жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 16-ны өдрийн
А/790 дүгээр захирамжийн хавсралт



“ҮЙЛДВЭРЛЭГЧ ХОВД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
ЗЭЭЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Төслийн нэр	Олгосон зээл	Олгох зээл
1	“Хан Алтайн инээмсэглэл” бүрэн бус нөхөрлөлийн /ББН/	“Амин хүнс” сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах цехийн үйл ажиллагааг өргөтгөх	35 000 000	5 573 618
	Нийт дүн	1 төсөл	35 000 000	5 573 618

-оОо-